

1. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар

Геодези, зураг зүйн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлоход санал оруулах, салбарын боловсон хүчний бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, салбарт шинээр нэвтэрч байгаа техник технологийг нийтийн хүртээл болгох, нийтийг хамарсан сургалт зохион байгуулах замаар Монгол улсын хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах зорилгоор хамтран ажиллаж байна.



2. Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо

Геодезийн салбар нь геодезийн мэргэжлийн холбоо болох “Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо” ТББ-тай хамтарч ажиллаж тус холбооноос зохион байгуулдаг “Мэргэшсэн болон зөвлөх инженерийн багц цаг тооцох сургалт”-д салбарын багш нараас хичээл зааж байна. Мөн “Геодези, зураг зүй мэргэжлийн сэтгүүл”-ийн редакцийн зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд салбарын багш нараас орж ажиллаж байна.



3. Монголын гео-мэдээллийн холбоо

Монгол улсын гео-мэдээллийн салбарын боловсон хүчнүүдийн ажил мэргэжлийн ур чадвар, судалгаа шинжилгээний аргачлал, технологийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, тэдгээрт тулгуурласан хэрэглээг хөгжүүлэх, ашиглах, дэмжихэд хамтран ажиллаж байна.



**МОНГОЛЫН
ГЕО-МЭДЭЭЛЛИЙН
ХОЛБОО**

4. Геодезийн компаниуд

Оюутан суралцагчдыг үйлдвэрлэлд дадлагажуулах, сургалтын орчинг сайжруулах, багаж тоног төхөөрөмж, програм хангамжийн тоог нэмэгдүүлэх, богино хугацааны сургалтууд зохион байгуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.

